



МОНГОЛ УЛС  
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,  
И-мэйл: comcog@iaac.mn, Вэб сайт: http://iaac.mn

2023.04.20 № 01/6703  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН,  
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙД Л.ЭНХ-АМГАЛАН ТАНАА

Зөвлөмж хүргүүлэх тухай


Авлигатай тэмцэх газар нь Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.4.2-т "Авлига гарч болох нөхцөл боломж бүрдүүлсэн гэж үзвэл төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан тушаал, шийдвэр, журам, дүрмийг хянаж хүчингүй болгуулах санал боловсруулж эрх бүхий байгууллагад оруулах" бүрэн эрхийн хүрээнд төрийн байгууллага, албан тушаалтны баталсан дүрэм, журам, шийдвэрийг хянаж ажилладаг билээ.

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 346 дугаар тогтоолоор (1 дүгээр хавсралт) баталсан "Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит сургалтын тэтгэлэг олгох журам"-ыг хянан үзээд авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор зохих өөрчлөлтийг оруулах санал, зөвлөмжийг үүгээр хүргүүлж байна.

Зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээг авч, хариу мэдэгдэхийг хүсье.

Хувийг, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт.

ДАРГА,  
ТЭРГҮҮН КОМИССАР



З.ДАШДАВАА

Авлигатай тэмцэх газрын  
2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн  
01/6/2023 дугаар албан бичгийн хавсралт

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2022 ОНЫ 346 ДУГААР  
ТОГТООЛООР БАТАЛСАН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН НЭРЭМЖИТ СУРГАЛТЫН  
ТЭТГЭЛЭГ ОЛГОХ ЖУРАМД ӨГЧ БУЙ ЗӨВЛӨМЖ

*Зөвлөмж 1.* Журмын нийтлэг үндэслэлд Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн “Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хууль”-ийг үндэслэн зохицуулалт хийх;

*Зөвлөмж 2.* Журмын 1.6-д “Суралцагчид олгох зээл, тэтгэлгийн хэмжээ болон тэтгэлэг олгох суралцагчдын хяналтын тоог тэтгэлгийн төрөл тус бүрээр боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно” гэсэн нь “Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 346 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан Ерөнхийлөгчийн нэрэмжит сургалтын тэтгэлэг олгох журам”-ын нэр томъёотой уялдахгүй байна. Мөн Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4, 3.1.5-д заасан санхүүгийн хоёр өөр нөхцөл (тэтгэлэг-эргэн төлөгдөхгүй буцалтгүй мөнгөн тусламж, зээл-эргэн төлөгдөх нөхцөл бүхий мөнгөн тусламж) бүхий төрлүүдийг хольж тусгасныг өөрчлөн нэг мөр зохицуулалтыг хийх;

*Зөвлөмж 3.* Журмын 2.1.2 дугаар зүйлийн “Засгийн газар хоорондын болон яам, боловсролын зээлийн сангийн түвшинд хийгдсэн хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрийн хүрээнд бакалаврын хөтөлбөрт суралцуулах тэтгэлэг” гэснийг Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Боловсролын зээлийн сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журмын 2.8.4-тэй уялдуулан шинэчлэх. Мөн “Засгийн газар хоорондын болон яам, боловсролын зээлийн сангийн түвшинд хийгдсэн хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрийн хүрээнд бакалаврын үндсэн хөтөлбөрт суралцуулах тэтгэлэг” гэж тодорхой тусгах. Журмын заалт нь үндсэн ангийн хамааралгүй суралцагчдыг элсүүлэх эрсдэлтэй байна.

*Зөвлөмж 4.* Журмын 2.1.4-т “Бэлтгэл хөтөлбөрт суралцуулах тэтгэлэг (Энэ тэтгэлгийн хүрээнд гадаадын их сургуулийн суурь хөтөлбөрт, эсхүл дотоодын их сургуулийн бэлтгэл хөтөлбөрт суралцаж болно)” гэж заасан нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит сургалтын тэтгэлэг олгох журмын зорилготой нийцэхгүй байх тул дотоодын их сургуулийн бэлтгэл хөтөлбөрт суралцуулах тэтгэлэг гэж нийцүүлэх;

*Зөвлөмж 5.* Журмын 3.4-т “Энэ журмын 2.1.4-т заасан тэтгэлгээс өөрийн хүсэлтээр татгалзсан тохиолдолд онооны эрэмбээр авсан дарааллын дагуу иргэнийг бэлтгэл хөтөлбөрт элсүүлж болно” гэсэн нь өөрийн хүсэлтээр татгалзсан иргэний оронд шаардлага хангахгүй, сонгон шалгаруулалтад тэнцээгүй, сонгон шалгаруулалтад ороогүй иргэнийг бэлтгэл хөтөлбөрт элсүүлэх боломжийг бүрдүүлж байгаа нь тус журмын 3.5 дахь заалттай уялдахгүй байх тул өөрчлөлт оруулах;

*Зөвлөмж 6.* Журмын 3.7-д “Бэлтгэл хөтөлбөрийг амжилттай төгсөж, энэ журмын 2.1.1, 2.1.2-т заасан тэтгэлэгт хамаарах их, дээд сургуулийн албан ёсны урилга хүлээн авсан иргэнд тэтгэлэг олгох асуудлыг сонгон шалгаруулалтын Ажлын хэсэг шийдвэрлэнэ” гэсэн заалтыг “Бэлтгэл хөтөлбөрийг амжилттай

төгсөж, энэ журмын 2.1.1, 2.1.2-т заасан тэтгэлэгт хамаарах их, дээд сургуулийн албан ёсны урилга хүлээн авсан иргэнд тэтгэлэг олгох 2 дахь шатны сонгон шалгаруулалтыг Ажлын хэсэг зохион байгуулан дүгнэлтийг хийж, Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр баталгаажуулна” гэж өөрчлөх;

*Зөвлөмж 7.* Журмын 3.8-д “Бэлтгэл хөтөлбөрийг амжилттай дүүргэж чадаагүй иргэнийг дотоодын төрийн өмчийн их, дээд сургуульд хувийн хөрөнгөөр үргэлжлүүлэн суралцах боломжоор хангана” гэсэн нь төрийн өмчийн их сургуульд элсэх элсэлтийн босго оноо хангаагүй иргэнийг их, дээд сургуульд элсэгчээр бүртгэж авах нь эрсдэлийг үүсгэж байх тул журмыг нарийвчлан тодорхой болгох;

*Зөвлөмж 8.* Журмын 3.10.1-т “Их, дээд сургуулиас бакалаврын үндсэн хөтөлбөрт суралцах албан ёсны урилга авсан байх” гэж тусгасан нь бэлтгэл хөтөлбөрийн шаардлага хангасан албан ёсны урилгын нөхцөлийн босго шалгуурыг нарийвчлан тогтоогоогүйн улмаас дахин гадаад улсад улсын төлбөрөөр хэлний бэлтгэлд суралцах боломжийг олгож байгаа нь уг журмын нийтлэг үндэслэлд тодорхойлсон “олон улсад өрсөлдөх чадвартай иргэн” гэсэнтэй нийцэхгүй байна. Иймд “Их, дээд сургуулиас бакалаврын үндсэн хөтөлбөрт суралцах **бэлтгэл хөтөлбөрийн шаардлага хангасан**, албан ёсны урилга авсан” гэж тодорхой болгон өөрчлөх;

*Зөвлөмж 9.* Журмын 4.2-т “Тэтгэлэгт хөтөлбөрийн сонгон шалгаруулалтыг тухайн жилийн 2 дугаар улиралд, бэлтгэл хөтөлбөрийн сонгон шалгаруулалтыг 3 дугаар улиралд багтаан тус тус зохион байгуулна” гэснийг Засгийн газрын 2021 оны 347 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Боловсролын зээлийн сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.3-т заасантай уялдуулан хугацааг тодорхой болгон олон нийтэд мэдээлэх;

*Зөвлөмж 10.* Журмын 4.4 дүгээр зүйлд “Боловсролын үнэлгээний төв энэ журмын 3.2-т заасан шаардлага хангаж байгаа иргэдийн жагсаалтыг Монгол Улсын сум, хороо тус бүрээр гарган, аймаг, нийслэлийн боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн захиргааны байгууллагатай хамтран хянаж баталгаажуулан боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ” гэсэн заалтад мэргэжлийн бусад байгууллагын оролцоог хангаж, харилцан хяналттай ажиллах үр дүнг засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж тус бүрээр мэдээллийг ил тод болгох нь зүйтэй байна. *Тухайлбал*, Боловсролын ерөнхий газар, Боловсролын мэдээлэл технологийн төв ... гэх мэт;

*Зөвлөмж 11.* Журмын 4.6-д “Суралцагчдын бэлтгэл хөтөлбөрт хамрагдах сургуулийн хуваарийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хийнэ” гэсэн зохицуулалтад суралцагчдын бэлтгэл хөтөлбөрт төрийн болон төрийн бус өмчийн бүх сургуулийг жигд хамруулах асуудлыг судлан тусгаж, сонгон шалгаруулалтад үндэслэн зохион байгуулах, бэлтгэл хөтөлбөрт хамрагдах сурагчдын нэрсийг тодорхой болгон олон нийтэд мэдээлэх;

*Зөвлөмж 12.* Журмын 4.8-д “Журмын 3.10-д заасан шаардлагыг хангаагүй суралцагчийг бэлтгэл хөтөлбөрийн шалгалтын үнэлгээгээр эрэмбэлж, тэтгэлэг олгох асуудлыг сонгон шалгаруулалтын Ажлын хэсэг шийдвэрлэнэ” гэсэн нь тухайн журмын 2.1.1, 3.10.1, 3.10.2, Авлигын эсрэг хуулийн 3.1.4 дүгээр зүйлд заасан давуу байдал олгох эрсдэлтэй тул Боловсролын зээлийн сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журмын 2.8.4 дэх заалттай уялдуулан журмыг шинэчлэх;

*Зөвлөмж 13.* Журмын 4.9-д “Энэ журмын 2.1.1-2.1.3-т заасан тэтгэлэгт сургалтын болон оюутны дотуур байрны төлбөр, амьжиргааны тэтгэлэг, 2.1.4-т заасан тэтгэлгийн хүрээнд гадаадын их сургуулийн суурь хөтөлбөрт хамрагдах

бол сургалтын болон оюутны дотуур байрны төлбөр, амьжиргааны тэтгэлэг, харин дотоодын их сургуулийн бэлтгэл хөтөлбөрт хамрагдах бол сургалтын болон оюутны дотуур байрны төлбөр тус тус хамаарна” гэснийг доорх хууль тогтоомжид нийцүүлэх. Үүнд:

*Тухайлбал, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 3.1.4 дүгээр зүйлд “Суралцагчийн тэтгэлэг” гэж дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчийн суралцах болон амьжиргааны зардлыг бүхэлд нь буюу тодорхой хэсгийг санхүүжүүлэхэд зориулан олгох буцалтгүй мөнгөн тусламж”;*

Захиргааны ерөнхий хуулийн 60.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон бусад хуульд нийцсэн байх, 60.1.2.тусгайлан эрх олгосон тухайн хуулийн агуулга, зорилго, хүрээнд нийцсэн байх шаардлагыг хангах;

Засгийн газрын тусгай сангийн хуулийн 26.1.Тусгай сангийн хөрөнгийг батлагдсан төсвөөс хэтрүүлэх, хуульд зааснаас өөр зориулалтаар ашиглах, зарцуулахыг хориглоно.

*Зөвлөмж 14.* Журмын 5.1.2-т “Засгийн газар хоорондын болон яам, боловсролын зээлийн сангийн түвшинд хийгдсэн хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрийн хүрээнд хэрэгжүүлж байгаа хөтөлбөрийн хөрөнгө” гэсэн санхүүжилтийг Боловсролын зээлийн сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журмын 3.3.2, 3.4-3.6 дахь заалтуудтай дүйцүүлэн журамд тусгах;

*Зөвлөмж 15.* Журмын 6.3-т “Тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдсан иргэн сургуулиа төгссөний дараа энэ журмын 6.1-д заасан гэрээний дагуу засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид 5-аас доошгүй жил ажиллана” гэсэн нь хэт ерөнхий ажиллах байгууллага нь тодорхой бус тул тавигдах шаардлага шалгуур үзүүлэлтийг журам болон гэрээний нөхцөлд нарийвчлан тусгах, төрийн албанд ажиллахгүй бол ямар хариуцлага хүлээлгэх, төлбөр хохирлыг хэрхэн төлүүлэх зэрэг асуудлыг оновчтой тусгаж өгөх;

*Зөвлөмж 16.* Журмын 6.4-д “Тэтгэлгийн баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн, суралцагчийн мэдээллийг буруу гаргасан буюу сурлагын үнэлгээг бодитой бус үнэлсэн нь тогтоогдвол буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ” гэсэн нь ямар хууль тогтоомжийг үндэслэн хэрхэн хариуцлага хүлээлгэх талаар тодорхой тусгаж, хохирлыг тодорхойлж, төлүүлэх талаар зохицуулалтыг тодорхой тусгах;

*Зөвлөмж 17.* Журмын 6.5-д “Сонгон шалгаруулалттай холбогдон гарсан маргааныг энэ журмын 4.3-т заасан Ажлын хэсэг шийдвэрлэнэ” гэсэн нь тэтгэлэгтэй холбоотой гомдлыг Ажлын хэсэг өөрөө шалгаж шийдвэрлэхээр тусгасан нь учир дутагдалтай бөгөөд Боловсролын зээлийн сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журмын 8.3, Авлигын эсрэг хуулийн 7, 8, 9 дүгээр зүйлд нийцүүлэн, ашиг сонирхлын зөрчил үүсгэхгүй, хөндлөнгийн хяналттай байхаар зохицуулалтыг хийх;

*Зөвлөмж 18.* Журмын 5 тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдаж, сургуулиа амжилттай төгссөн иргэний төлбөрийн зээлийн чөлөөлөх асуудлыг нарийвчлан зохицуулах, гэрээг дүгнэхгүй, хууль бусаар үндэслэлгүй чөлөөлсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага, хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг тодорхой тусган журамлах, ил тод байдлыг хангуулах арга хэмжээг авах;

*Зөвлөмж 19.* Тухайн төгсөгчийн нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг тооцохдоо цалингийн доод хэмжээ, сайн дурын даатгал төлсөн хугацааг нийт хугацаанд оруулан тооцохгүй байх, ийм тохиолдолд хүлээлгэх хариуцлагын талаар зохицуулалтыг тодорхой болгох;

*Зөвлөмж 20.* Боловсролын зээлийн сангаас гадаадын их, дээд сургуульд суралцах тэтгэлэгт хамрагдсан иргэний барьцаа хөрөнгийг баталгаа болгон гаргуулж, улсын бүртгэлд барьцаалсан талаар тэмдэглэгээ хийлгэх, сангаас зээл, тэтгэлэг авсан хүн тус бүрийн талаарх мэдээллийг Монгол банкны зээлийн мэдээллийн санд бүртгэж, эргэн төлөлтөд хяналт тавих асуудлыг нэмж тусгах.

*Зөвлөмж 21.* Боловсролын зээлийн сангаас гадна *Тухайлбал*, Иргэний нисэхийн ерөнхий газар, Ашигт малтмал, газрын тосны газар зэрэг байгууллагаас зохион байгуулж байгаа сургалтын тэтгэлэг олгох үйл ажиллагааг Боловсролын зээлийн сангаар дамжуулан зохион байгуулах, асуудлыг судлан шийдвэрлэж журамд тусгах;

*Зөвлөмж 22.* Засгийн газраас олгож байгаа сургалтын зээл, тэтгэлэгтэй холбоотой үйл ажиллагааны төлөвлөлт, зохион байгуулалт, сонгон шалгаруулалт, үр дүн, үйл ажиллагааны тайлагнасан байдал зэрэг бүхий л үе шатны мэдээллийг ил тод нээлттэй мэдээлэх зорилгоор нэгдсэн цахим платформ ажлуулах асуудлыг судалж, журамлах, зохион байгуулах;

---oOo---